



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Арвайхээр сумын Арвайхээр тохижилт үйлчилгээ ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: Аудитын код: ӨВА-2022/2/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2022 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг:
gansukh.audit@gmail.com

Ахлах аудитор: Ц.Мөнхзаяа

Утас: 70323108 Цахим хаяг: Munkhzayats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	7
3.1 Байгууллагын үйл ажилагаа	7
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	7
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	7
4. Аудитын тайлан	9
4.1 Ерөнхий зүйл	9
4.2 Дотоод хяналт	9
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
4.4 Материаллаг байдал	9
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
5.1 Шилэн дансны мэдээлэл	10
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	10
8. Аудитын илрүүлэлт	11
8.1 Залруулсан алдаа	11
8.2 Төлбөрийн акт	11
8.3 Албан шаардлага	11
8.4 Зөвлөмж	11
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг
Утас/факс: (076) 7032 3253
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

АРВАЙХЭЭР ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ
ААТҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.СҮХ-ӨЛЗИЙ ТАНАА

2022.05.24 № 224
танай _____-ны № _____-г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Арвайхээр тохижилт үйлчилгээ ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Арвайхээр тохижилт үйлчилгээ ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

01503047

D:\Auditin gazar\baiguullagiin dotood barimt\A4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/мян.төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	0.0	0.0
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	9,741.0	23,089.1
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	817.8	
1.1.4	Бусад авлага	9,010.0	16,389.4
1.1.6	Бараа материал	85,128.8	154,897.4
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	104,697.6	194,375.9
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,496,373.6	1,317,442.8
1.2.9	Үнэт зүйл	12,320.0	12,320.0
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,508,693.6	1,329,762.8
1.3	Нийт хөрөнгийн дүн	1,613,391.2	1,524,138.7
2.1.1.2	Цалингийн өглөг	817.8	65.9
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	6,046.7	18,000.0
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	7,004.5	18,065.9
2.2	Өр төлбөрийн нийт дүн	7,004.5	18,065.9
2.3	Өмч	2,689,851.5	2,689,851.5
2.3.1	-төрийн	2,689,851.5	2,689,851.5
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	41,181.2	41,181.2
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-1,124,646.0	-1,224,959.9
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,606,386.7	1,506,072.8
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	1,613,391.2	1,524,138.7

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/мян.төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,955,944.8	1,141,542.7
3	Нийт ашиг (алдагдал)	1,955,944.8	1,141,542.7
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,289,021.1	1,207,750.0
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-1,387,040.2	-34,106.6
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-720,116.5	-100,313.9
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	-720,116.5	-100,313.9
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-720,116.5	-100,313.9
24	Орлогын нийт дүн	-720,116.5	-100,313.9

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/мян.төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	20.. оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	2,689,851.5	0.0	41,181.2	0.0	-404,529.5	2,326,503.2
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

	нөлөө, алдааны залруулга						
2	Залруулсан үлдэгдэл	2,689,851.5	0.0	41,181.2	0.0	-404,529.5	2,326,503.2
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	0.0	0.0	-720,116.5	-720,116.5
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
5	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
6	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
8	20.. оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	2,689,851.5	0.0	41,181.2	0.0	-1,124,646.0	1,606,386.7
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2	Залруулсан үлдэгдэл	2,689,851.5	0.0	41,181.2	0.0	-1,124,646.0	1,606,386.7
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	0.0	0.0	0.0	-100,313.9	-100,313.9
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
5	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
6	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
8	20.. оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	2,689,851.5	0.0	41,181.2	0.0	-1,224,959.9	1,506,072.8

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

				/мян.төгрөгөөр/	
№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл		
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0		
1.1	Мөнгөн орлогын дүн	1,045,582.2	1,085,642.8		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	847,837.5	908,138.6		
1.1.6	Бусад мөнгөн орлого	197,744.7	177,504.2		
1.2	Мөнгөн зарлагын дүн	1,079,438.9	1,032,991.7		
1.2.1	Ажиллагчдад төлсөн	582,279.4	527,265.8		
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	84,315.9	68,299.8		
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	199,560.5	229,604.1		
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	12,609.9	16,086.2		
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	112,586.4	154,107.2		
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	24,413.3	21,322.7		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	63,673.5	16,305.9		
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-33,856.7	52,651.1		
2.2	Мөнгөн зарлагын дүн	0.0	39,303.0		
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.0	39,303.0		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.0	-39,303.0		
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-33,856.7	13,348.1		
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	43,597.7	9,741.0		

6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	9,741.0	23,089.1
---	--	---------	----------

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2020 оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,095,383.75	1,072,294.67	23,089.08	98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,095,383.75	1,072,294.67	23,089.08	98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,074,061.11	1,050,972.03	23,089.08	98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	527,266.45	527,265.77	0.68	100
210101	Үндсэн цалин	394,871.13	394,870.44	0.68	100
210102	Нэмэгдэл	73,809.83	73,809.83	0.00	100
210103	Унаа хоолны хөнгөлөлт	58,585.50	58,585.50	0.00	100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,299.82	68,299.81	0.02	100
210201	Тэтгэврийн даатгал	48,179.34	48,179.32	0.02	100
210202	Тэтгэмжийн даатгал	5,258.93	5,258.93	0.00	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,207.15	4,207.15	0.00	100
210204	Ажилгүйдлийн даатгал	968.58	968.58	0.00	100
210205	Эрүүл мэндийн даатгал	9,685.82	9,685.82	0.00	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,087.00	16,086.23	0.77	100
210301	Гэрэл, цахилгаан	7,503.00	7,502.99	0.01	100
210302	Түлш, халаалт	7,842.00	7,841.25	0.75	100
210303	Цэвэр, бохир ус	742.00	741.99	0.01	100
2104	Хангамж, бараа материалын зардал	292,590.70	269,683.89	22,906.81	92
210401	Бичиг хэрэг	3,193.70	3,192.85	0.85	100
210402	Тээвэр, шатахуун	86,000.00	85,991.83	8.17	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,348.00	2,347.77	0.23	100
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200.00	1,183.35	16.65	99
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	35,000.00	35,000.00	0.00	100
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	164,849.00	141,968.10	22,880.90	86
2105	Нормативт зардал	20,057.30	20,057.30	0.00	100
210502	Хоол, хүнс	2,865.00	2,865.00	0.00	100
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,192.30	17,192.30	0.00	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	91,470.40	91,470.10	0.30	100
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	23,355.00	23,354.70	0.30	100
210604	Урсгал засвар	68,115.40	68,115.40	0.00	100
2107	Томиллолт, зочны зардал	2,500.00	2,500.00	0.00	100
210702	Дотоод албан томиллолт	2,500.00	2,500.00	0.00	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,299.43	6,295.53	3.90	100
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,232.00	1,232.00	0.00	100
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,200.00	1,200.00	0.00	100
210803	Даатгалын үйлчилгээ	1,581.60	1,581.60	0.00	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,255.24	1,255.24	0.00	100
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	187.00	187.00	0.00	100
210807	Газрын төлбөр	743.60	743.60	0.00	100
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	100.00	96.10	3.90	96
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,490.00	49,313.40	176.60	100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,490.00	49,313.40	176.60	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,322.64	21,322.64	0.00	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,322.64	21,322.64	0.00	100
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,002.64	9,002.64	0.00	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,320.00	12,320.00	0.00	100
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	9,740.96		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		23,089.08	-23,089.08	

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Сумандаа Монгол улсын хууль тогтоомжийг сурталчлан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, улсын болон аймаг, сумынхаа төсвийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж, өөрийгөө санхүүжүүлэх эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэхэд оршино” гэсэн зорилт дэвшүүлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар статустай байна. Өмчийн 100 хувийг орон нутаг эзэмшиж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Арвайхээр тохижилт үйлчилгээ ААТҮГ нь 2014 оны 09 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Арвайхээр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор 5 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна..

Арвайхээр тохижилт үйлчилгээ ААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд цалин, урамшуулал олгоогүй байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчилж, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог бууруулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоосон байна

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Арвайхээр тохижилт үйлчилгээ ААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9,741.0	23,089.1	13,348.1
БХХО			
Авлага	9,827.8	16,389.4	6,561.6
Урьдчилгаа			
Бараа материал	85,128.8	154,897.4	69,768.6
Үндсэн хөрөнгө	1,508,693.6	1,329,762.8	-178,930.8
Биет бус хөрөнгө			
Нийт хөрөнгийн дүн	1,613,391.2	1,524,138.7	-89,252.5
Өр төлбөрийн дүн	7,004.5	18,065.9	11,061.4
Богино хугацаат өглөг	7,004.5	18,065.9	11,061.4
Урт хугацаат өглөг			
Эздийн өмч	1,606,386.7	1,506,072.8	-100,313.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,613,391.2	1,524,138.7	-89,252.5

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 23.1 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд байгууллагаас авах авлага 9.8 сая төгрөг хувь хүмүүсээс авах авлага 6.5 сая төгрөгийг эзэлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 154.9 сая төгрөг болж 69.8 сая төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материал, тусгай зориулалтын материал, аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл, түлш шатах тослох материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Тайлант онд үндсэн хөрөнгө 73.9 сая төгрөг үнэ төлбөргүй хүлээн авсан, 39.3 сая худалдан авсан хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Тээврийн хэрэгсэл 229.8 сая төгрөгөөр, машин тоног төхөөрөмж 0.02 сая төгрөгөөр, тавилга эд хогшил 0.9 сая төгрөг, бусад үндсэн хөрөнгө 5.9 сая төгрөгөөр акталсан байна

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 18.1 сая төгрөгийн өр төлбөр байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Гүйцэтгэлээр 1085.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1072.3 сая төгрөгийн зардал гарган, 13.3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1095.4 сая төгрөг болж төлөвлөснөөс 1095,4 сая төгрөг орлого бүрдсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1095.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1072.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Арвайхээр тохижилт үйлчилгээ ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад Арвайхээр тохижилт үйлчилгээ ААТҮГ-ын холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022.02.20-аас 2022.02.25-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.02.25-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Ц.Мөнхзаяа хариуцаж хэрэгжүүлэв..

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.02.21-ний өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 1 гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 75 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн зардал 1207.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 12.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 9.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Арвайхээр тохижилт үйлчилгээ ААТҮГ-ын 2021 оны 4 дүгээр улиралд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 149 мэдээллийг ил тод мэдээлсэн байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар илэрсэн зөрчил бүрэн биелэгдсэн байна

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	3	317.2	3	317.2			
Нийт дүн	3	317.2	3	317.2			

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төрийн боон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авсан ажил үйлчилгээг гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 72.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 72.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 66510,0 мянган төгрөгийн зөрчил материаллаг бус, 6420.0 мянган төгрөгийн зөрчил материаллаг бөгөөд материаллаг байдлын түвшнээс хэтрээгүй тул Зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд залруулсан алдаа зөрчил гараагүй.

8.2 Төлбөрийн акт

байхгүй

8.3 Албан шаардлага

1.1 Илрүүлэлт:

1. Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс зардлаас нохой устгах зардал гаргасан
2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авсан гэрээг зөрчиж уг ажлыг өөр байгууллагаар гүйцэтгүүлсэн

Өгсөн албан шаардлага

1. Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Монгол улсын Сангийн сайдын 2021 оны 10 сарын 29-ний өдрийн 190-р тушаалыг мөрдөж ажиллах

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.2 Илрүүлэлт:

Хөрөнгийн тооллого, жолоочийн тооцооны хуудсыг батлагдсан маягтын дагуу хөтлөөгүй байна.

1.2. Эрсдэл:

Холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллахад эрсдэл үүсэж байна..

1.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн "13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. 3.6. Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" зэрэг заалтыг хэрэгжүүлэх ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж		
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
																	Тоо
Санхүүгийн тайлангийн асуудлаар																	
1	Арвайхээр Тохижилт Үйлчилгээ ААТҮГ СТА-ОНА	ӨВА-2022/2/НА-2022/2/НА-СТА-ОНА	Хөрөнгийн тооллого, жолоочийн тооцооны хуудсыг батлагдсан маягтын дагуу хөтлөх	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. 3.6.Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.	1											1	
2	Арвайхээр Тохижилт Үйлчилгээ ААТҮГ СТА-ОНА	ӨВА-2022/2/НА-2022/2/НА-СТА-ОНА	Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс зардлаас нохой устгах зардал гаргасан	Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах. Монгол улсын Сангийн сайдын 2021 оны 10 сарын 29-ний өдрийн 190-р тушаалыг мөрдөж ажиллах	1					1	6420,0						
ДҮН					2				1	6420,0						1	
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																	
1	Арвайхээр Тохижилт Үйлчилгээ ААТҮГ СТА-ОНА	ӨВА-2022/2/НА-2022/2/НА-СТА-ОНА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.	1					1	66510,0						
ДҮН					1				1	66510,0							
НИЙТ ДҮН					3				2	72930,0						1	

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 АУДИТЫН МЕНЕЖЕР
 БЭЛТГЭСЭН АУДИТОР

О. БАТЖАРГАЛ
 Д. ГАНСҮХ
 Ц. МӨНХЗАЯА

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн бүртгэлийн мавит

Аудитын нэр: Санхүүгийн тайлагийн аудит

Аудитын код: БВА-2022/21НА-СТА-ТШЗ

Байгууллагын нэр: Арвайхээр тохиомллт үйлчилгээ ААТҮГ

№	Ажил гүйцэтгэлийн анги, дансны үндэсдэл, тодруулга	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагч байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хэрхэ, тайлбар	Гаргасан шийдэл	Шалгагч байгууллагын Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	Няглан бодох бүртгэл	Хөрөнгийн тооллого, жолоочийн тооцооны хуудсыг батлагдсан маягтын дагуу хөтөх	0.0	зөвлөмж	Санал байхгүй.	Няглан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. 3.6 Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.	зөвлөмж	Гүйцэтгэх захирал Нягтлан бодогч	Д.Сүх-Өлзий Ц.Янжмаа
2	Урсгал зардал	Бага үнэтэй түргэн эзлэгдэх, ажлын эд зүйлс зардлаас нохой устгах зардал гаргасан	6420.0	албан шаардлага	Санал байхгүй.	Төвийн тухай хуулийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхыг төлөвлөж, зарцуулах, Монгол улсын Сангийн сайдын 2021 оны 10 сарын 29-ний өдрийн 190-р тушаалыг мөрдөж амжиллах	албан шаардлага	Гүйцэтгэх захирал Нягтлан бодогч	Д.Сүх-Өлзий Ц.Янжмаа
3	Урсгал зардал	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авсан, сэрээ, зөрчиж уг ажлыг өөр байгууллагаар гүйцэтгүүлсэн	66510.0	албан шаардлага	Санал байхгүй.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41.2. Гүйцэтгэх гэрээгээр хүлээсэн үүргээ гурвадгач этгээдэд шилжүүлэхийг хориглоно.	албан шаардлага	Гүйцэтгэх захирал Нягтлан бодогч	Д.Сүх-Өлзий Ц.Янжмаа

72930.0

Бэлтгэсэн:

АУДИТОР

АНХАН ШАТНЫ ХЯНАГЧ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Хөвөр дахь шатанд хянасан

ДАРГА, ТЭГЭГЦЭГХ АУДИТОР

Ц.МОНХУУЯА
Д.ГАНСЖ
О.БАТЖАРГАЛ

Танилцаж зөвшөөрсөн:

АРВАЙХЭЭР ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

НЯГТЛАН БОДОГЧ

Д.СҮХ-ӨЛЗИЙ
Ц.ЯНЖМАА
110001356 ZUB



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 0818-2022/2/НА-СТА-Түүс/А1570351/142

Арвайхээр

Арвайхээр тохижилт үйлчилгээ ААТҮГ-ын
гүйцэтгэх захирал Д.Сүх-Өлзий танаа
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авсан 66510.0 мянган төгрөгийн гэрээт ажлыг өөр байгууллагаар гүйцэтгүүлсэн зөрчил илэрсэн байна.

Энэ нь "Төсвийн тухай хуулийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Дээр дурдсан гэрээгээр хүлээсэн үүргээ бусдад шилжүүлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Арвайхээр тохижилт үйлчилгээ ААТҮГ-ын гүйцэтгэх захирал Д.Сүх-Өлзий, нягтлан бодогч Ц.Янжмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
О.БАТЖАРГАЛ
Ц.МӨНХЗАЯА



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 24 өдөр

Дугаар ДВА-2022/2/НА-СТА-ТүүЗ/Н1570351/143

Арвайхээр

Арвайхээр тохижилт үйлчилгээ ААТҮГ-ын
гүйцэтгэх захирал Д.Сүх-Өлзий танаа
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Санхүүгийн тайлангийн аудитаар бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс зардлаас нохой устгах зардал гаргасан зөрчил илэрсэн байна.

Энэ нь "Төсвийн тухай хуулийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Монгол улсын Сангийн сайдын 2021 оны 10 сарын 29-ний өдрийн 190-р тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй байна..

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Дээр дурдсан бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс зардлаас нохой устгах зардал гаргасан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Арвайхээр тохижилт үйлчилгээ ААТҮГ-ын гүйцэтгэх захирал Д.Сүх-Өлзий, нягтлан бодогч Ц.Янжмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  О.БАТЖАРГАЛ
АУДИТОР  Ц.МӨНХЗАЯА

